
НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2017.12.08

Тайлант хугацаанд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”, Агаарын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, шийдвэр дүрэм журмын дагуу шийдвэрлэж ажиллав.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу тус газар бодлогын 4 баримт бичгийн 15 тэргүүлэх зорилтоос 26 арга хэмжээ гүйцэтгэлийн биелэлтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар гаргалаа. Жилийн эцсийн байдлаар бүрэн биелэгдсэн 8, бусад арга хэмжээнүүд хэрэгжилтийн шатанд байна.

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус газарт хамаарал бүхий 2 зорилт, 2 арга хэмжээний хэрэгжилт 50%

1.1. Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тус газарт хамаарал бүхий 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилт 70%

1.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 3 зорилт, 10 арга хэмжээний хэрэгжилт 85%

1.3. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 9 зорилт, 13 арга хэмжээ тусгагдсанаас бусадтай хамтран хэрэгжүүлэх 4, хариуцан хэрэгжүүлэх 9 байгаа бөгөөд хэрэгжилтийн гүйцэтгэл 79,6 %

Улс, нийслэлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ажлын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулах тухай А/163 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 12 ажлын жагсаалт батлагдсанаас бүгд ажил гэрээ хийгдэж, гүйцэтгэлүүдийг хүлээж аваад байна. Хэрэгжүүлж буй ажлуудын сонгон шалгаруулалтын явцыг талаах мэдээлэл:

1. Агаарын чанарын мониторингийн тасралтгүй ажиллах ажлын хүрээнд “Агаар орчны хяналтын суурин харуулын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх” НАББГ/201703001 арга хэмжээний гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. 2017 оны 05 дугаар сарын 22-ний өдөр тендерт оролцогч байгууллагуудын саналыг хүлээн авч, нээлт хийсэн ба тендерийн баримт бичгийг 6 аж ахуйн нэгж худалдан авснаас 1 аж ахуйн нэгж санал ирүүлсэн. Энэхүү ажлын гүйцэтгэгчээр “Интер сайнс” ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд гүйцэтгэлийг бүрэн хүлээлгэн өгсөн.

2. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/163 дугаар захирамжаар батлагдсан “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 1700 айл өрхөд сайжруулсан түлш олгохоор нээлттэй сонгон шалгаруулалтыг НХААГ-т зарласан. “Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах” НАББГ-2017/ тоот гэрээг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Баялаг Эрдэнэ цом” ХХК-тай байгуулсан. Уг ажлын хүрээнд 1700 тонн сайжруулсан түлш олгохоос одоогийн байдлаар 204 тонн сайжруулсан түлшийг Сонгинохайрхан дүүргийн 1-8,20,22,25 дугаар хороонд буулгаж хүлээлгэн өгсөн.


3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид эрх шилжүүлсний дагуу улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх Агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/588 тоот захирамжаар баталсан. Уг ажлын хүрээнд 2100 тн-оос багагүй сайжруулсан шахмал түлш нийлүүлэх сонгон шалгаруулалтын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зарлан 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нээлт хийсэн. Хамгийн сайн үнэлэгдсэн “Монголиан Инвестмент Корпорейшн” ХХК-д 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн боловч Сангийн яаманд гомдол гарсан.

4. Шөнийн эрчим хүчний хэрэглээг зүй зохистой ашиглах, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг дэмжих улмаар түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах зорилгоор “Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг дэвшилтэт технологи бүхий халаагуураар хангах” ажлын техникийн тодохойлолтыг боловсруулж НХААГ-т хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас “Монватт” ХХК-тай гэрээ байгуулах мэдэгдлийг 2017 оны 11 дүгээр сарын 28-нд ирүүлсэн бөгөөд 2017 оны 12 сарын 04-ний өдөр “Монватт” ХХК-тай 180 ширхэг дэвшилтэт технологи бүхий халаагуурын гэрээ байгуулан НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэв. Мөн агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг дэвшилтэд технологи бүхий зуухаар хангах нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж гүйцэтгэгчээр шалгарсан “Бэст Энержи сейвинг” ХХК-тай гэрээ байгуулсан. Нийслэлийн гэр хорооллын агаарын чанарын сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг 200 ширхэг дэвшилтэт технологи бүхий цахилгаан халаагуураар хангана.

5. Нийслэлийн өмчийн 10-аас доошгүй барилгын халаалтыг байгальд ээлтэй эх үүсвэрээр хангах зорилгоор техникийн тодорхойлолтыг боловсруулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. “Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн халаалтыг байгальд ээлтэй эрчим хүчний эх үүсвэрээр хангах” НХААГ/201704143 дугаарт ажлын гүйцэтгэгчийг НХААГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/48 дугаарт тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 06 дугаар сарын 27-нд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. 2017 оны 11 дүгээр


сарын 07-ны өдөр “Баянмогод” ХХК-тай гэрээг байгуулсан бөгөөд гүйцэтгэл хүлээж авах хүсэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн. Нийслэлийн Агаарын бохирдлын бууруулах газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/35 тушаалаар ажлын гүйцэтгэл хүлээж авах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

6. Нийслэлийн Агаарын чанарыг сайжруулах бүсийн “Сургууль цэцэрлэг эмнэлгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэх” НАББГ-2017/03 дугаарт гэрээг “Галтбамбай секьюрити ХХК”-тай 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 350 ХЕПА агаар цэвэршүүлэгчийг агаарын чанарыг сайжруулах бүсийн 21 сургуулийн бага ангид, дүүргүүдийн нэгдсэн эмнэлгийн 11 эрүүл мэндийн төвийн хүүхдийн эрчимт болон хэвтүүлэн эмчлэх тасгуудад олгох ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр дуусган, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсөн.




7. Нийслэлийн өмчийн 10-аас доошгүй усан халаалтын зуухнуудад шүүлтүүр суурилуулах ажлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2017 оны 05 дугаар сарын 26 – ны өдөр зарлаж гүйцэтгэгчээр шалгарсан Баяндөрвөлж” ХХК нь 2017 оны 08 дугаар сарын 11-ны өдөр 10 байршлын 19-н зууханд синтетик платин катализатор суурилуулах гэрээ байгуулсан. 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдөр 9 байршлын 17 зууханд синтетик платин катализатор суурилуулж дуусч хүлээж авах комисс ажиллуулах хүсэлтийг ирүүлсний дагуу ажлын хэсэг гарч хүлээн авч санхүүжилтийг шийдвэрлэсэн. Боловсрол, соёл, шинжлэх ухаан,спортын яамны захиалгаар Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах 104 дүгээр сургуулийн өргөтгөлийн

барилга угсралт, уурын зуух суурилуулах ажлаас шалтгаалан 1 байршлын 2 зууханд синтетик платин катализатор суурилуулж чадахгүй ажил нь зогссон. БСШУСЯ-наас 2017оны 11дүгээр сарын 03-ны өдрийн 16/10425 тоот албан бичгээр 104 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын үндсэн тогооны ажил дууссан ба галлагааны ажлыг эхлүүлэхээр төлөвлөн үлдсэн хуучин зуухны барилгыг буулгаж нөөцийн тогооны ажлыг эхлүүлэхээр ажиллаж байгаа тул уг ажил 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр дуусах төлөвлөгөөтэй байгааг мэдэгдсэн.



8. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны А/163 дугаар захирамжаар батлагдсан “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээний хүрээнд “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллого явуулах” нийслэлийн дундын мэдээллийн санд байршуулах программ зохион бүтээлгэхээр нээлттэй сонгон шалгаруулалтыг 2017 оны 05 дугаар сарын 23-нд зарласан. “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл, тооллого явуулах бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх” НАББГ/201704003 дугаар бүхий гэрээг “Бидсолюшн” ХХК-тай 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулж гүйцэтгэлийг бүрэн хүлээн авсан.



9. Телевизийн 4 нэвтрүүлэг, 4 анимэйшн, 1 шторик бэлтгэн, 3-аас доошгүй телевизээр 7 хоногт 3-аас доошгүй давтамжтайгаар 2 сарын хугацаанд иргэд олон нийтэд сурталчлах “Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа, журмыг хэвлэл мэдээллээр сурталчлах” НАББГ/201704002-1 дугаарт сонгон шалгаруулалтыг 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдөр зарласан бөгөөд 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдөр нээлтээ хийж хамгийн сайн үнэлэгдсэн "Гэр монголын маркетингийн агентлаг" ХХК-тай 2017 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр гэрээ байгуулсан. Гүйцэтгэлийн эхлэл, дунд үеийн тайлангуудыг ирүүлсэн. Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа, журмыг иргэд олон нийтэд сурталчлах ажлын зураг авалт хийгдэж эхний нэвтрүүлгүүд цацагдахад бэлэн болсон.

10. Дэвшилтэт технологи бүхий зуух халаагуураар хангах НАББГ/201703004 дугаар бүхий сонгон шалгаруулалтыг НАББГ-т зарлаж гүйцэтгэгчээр “Ультрасоник” ХХК шалгарч гэрээ байгуулах мэдэгдлийг НБОГ-т хүргүүлж 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан. Энэхүү ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ультрасоник” ХХК-ны ажлын гүйцэтгэлийг НАББГ-аас “ажлын хэсэг” гарч хүлээн авсан бөгөөд санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

ХОЁР. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамаарал бүхий 7 тогтоол, 8 захирамжийн 29 заалтыг бүтэн жилийн байдлаар хяналтанд авч хэрэгжилтийг monitoring.ub.gov.mn программаар тайлагнаж ажиллав.

1. Улсын Их Хурлын 2 тогтоолын 5 заалтын хэрэгжилт 42%
2. Улсын Их Хурлын Байнгын хорооны 1 тогтоолын 10 заалтын хэрэгжилт 71%
3. МУ-ын Засгийн газрын 2 тогтоол, 1 хуралдааны тэмдэглэлийн 4 заалтын хэрэгжилт 70%
4. МУ-ын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалтын хэрэгжилт 50%
5. НИТХ-ын 1 тогтоолын 1 заалтын хэрэгжилт 90%
6. Нийслэлийн Засаг даргын 7 захирамжийн 8 заалтын хэрэгжилт 88,7%

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Агаарын тухай хууль, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд


1. Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3-т заасныг тус тус үндэслэн Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмын төслийг боловсруулан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04-А/19 дугаарт хамтарсан тушаал, захирамжаар батлуулан гаргуулсан.

Тус журманд 4.2 МВт хүртэлх хүчин чадалтай ус халаах зуухны техник, экологийн шаардлага, норм /MNS 5043: 2016/- ыг тусгасан нь 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухнуудын ашиглалтыг магадлан итгэмжлэх, хяналт шалгалт хийх эрх зүйн орчинг шинэчилсэн.

-
2. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 /2016/, Ногоон хөгжлийн бодлого /2014/, Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр /2015/, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.11 дахь заалт, 10.4 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 6.1.1 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03/03 дугаар зөвлөмж зэрэг бодлого, хууль тогтоомжид агаар, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахыг заасан нь Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр боловсруулах эрхзүйн үндэслэл юм. БОАЖ-ын сайдын тушаалаар Төрийн захиргааны төв байгууллагуудын 17, яамдын харьяа агентлагуудын 4, нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор ахлуулсан 3 (Агаарын бохирдлыг бууруулах газраас 2), их, дээд сургууль, судалгааны хүрээлэнгүүдийн 8 эрдэмтэд бүхий нийт 32 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан, Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаарт тогтоолоор батлуулсан.
 3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаас гаргасан 03/03 зөвлөмжид “Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар орон нутгийн
 4. Орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх” асуудал тусгагдсан.
Энэхүү зөвлөмжийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллагуудтай хамтран “Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөө”-г боловсруулан, НИТХ-аар хэлэлцүүлэн 2017 оны 01-р сарын 27-ны өдрийн 07/01, 2017 оны 05-р сарын 18-ны өдрийн 10/14 дугаарт тогтоолуудаар батлуулан, хэрэгжилтийн биелэлтийг 7 хоног бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллаж байна.
 5. “Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ тогтоох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалаар батлагдсан тарифын хэмжээг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан “ Агаарын тухай” хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна. Мөн үйлчилгээний хөлс, хураамжаас олсон орлогыг Засгийн газрын тусгай сан “Цэвэр агаар сан”-д төвлөрүүлэн улмаар түүнийг агаарын чанарын хяналтын чадавхыг бэхжүүлэх, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж байх зорилтыг үүрэг болгосон хэдий ч тус “Сан” нь 2015 онд татан буугдсантай холбоотойгоор мэргэжлийн албаны хяналтын чадавхыг бэхжүүлэх боломжгүй болсон. Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8.-д “... мэргэжлийн албаны дүгнэлт гаргуулах үйлчилгээний
-

тарифыг тогтоох” гэж заасныг үндэслэн “Агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлт гаргуулах ажиллагааны хөлс, хураамжийн хэмжээ”-г шинэчлэн тогтоож, орлогыг Улс, нийслэлийн төсөвт төвлөрүүлж байх шийдвэрийн талаарх саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хүргүүлэх шийдвэрийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар гаргуулсан.

6. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 4 бүс байсныг 2017-2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн 3 бүс болгон шинэчлэн боловсруулсан. Бүсчлэлийг тогтоохдоо Орон сууцны ипотекийн зээлийн урдчилгаа төлбөрийн санхүүжилт олгох журам, Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газрын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хүргүүлээд байна.



Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, хүрээлэн буй орчинд мониторинг хийх зорилтын хүрээнд:

1. Тус газар нь агаарын чанарыг 5 суурин харуулаар 24 цагийн турш тасралтгүй хэмжиж агаарын чанарыг хянадаг бөгөөд хэмжилтийн баталгаат өгөгдлийг 7 хоног тутам, сар тутам баталгаажуулан ЦУОШГ-т мэдээллэдэг. 2017 онд 8760 цагийн хэмжилтийн өгөгдөл цуглуулах ёстой. Баталгаат өгөгдлийг суурин харуул тус бүрээр үзүүлвэл:

Толгойт - 8543 цаг – 97.52%

Телевиз - 8646 цаг – 98.70%

Амгалан - 8437 цаг – 96.31%

Нисэх - 8260 цаг – 94.29%

Баянхошуу - 8480 цаг – 96.80% байна.

Орчны 5 суурин харуулын мэдээг 7 хоног, сар тутам баталгаажуулж гэрээнд заасан хугацаанд ЦУОШГ-т хүргүүлсэн.

2. Агаарын чанарын хэмжилтийн баталгаат өгөгдлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Сөүл хоттой агаарын чанарын мэдээллийг харилцан солилцох ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 28-наас 12 дугаар сарын 02-ны хооронд Дарь-Эхийн агаар, орчны хяналтын суурин харуулыг БНСУ-ын мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар шаардлагатай засвар үйлчилгээний ажлыг хийж хэвийн үйл ажиллагаанд орууллаа.



3. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа агаарын чанарт нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд орчны болон эх үүсвэрийн хэмжилт хийж, хэмжилтийн дүнг нэгтгэн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажиллалаа. Энэхүү хэмжилтийн хүрээнд 39 аж ахуйн нэгжийн орчинд агаарын чанарын хөдөлгөөнт AQMS-9000 хөдөлгөөнт харуул болон суурин эх үүсвэрийн цогц багажаар хэмжилт хийж, 15,5 сая төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна. Үүнд: “Айзава Монгол” ХХК, “Шар Монгол” ХХК “Энвайрон” ХХК, “Тайм скүэйр” ХХК, “ЭиПи Ти” ХХК, “Эко Констракшн” ХХК, “Түмэн шувуут” ХХК, “Мөнххада” ХХК, “Алтан оршихуй” ХХК, Оргил зуурмаг ХХК, “Жи Эс Дорны хөгжил” ХХК, “Эйч Ди Ти Эм” ХХК, “Нарангийн гол” ХХК, “Аман Токо” ХХК, “Гуру травел” ХХК, “Монгол тамхи Со” ХХК, “Петровис” ХК-ны Шатахуун агуулах станц гэсэн байгууллагууд хамрагдлаа.



4. Нийслэлд 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 08:00-18:00 цагийн хооронд зохион байгуулсан “Автомашингүй өдөр” буюу автозамын хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарласантай холбогдуулан Тусгаар тогтнолын талбайн орчмын агаарын чанарыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнт үетэй харьцуулсан хэмжилтийг хийсэн. Хэмжилтийн дүнг харьцуулан харахад авто замын хөдөлгөөн хаасан үед агаарын бохирдлын хэмжээ (NO_2 , SO_2 , $\text{PM}_{2.5}$) 3-5 дахин бага байв.

Хяналт-шалгалт, судалгааны ажлын хүрээнд:

1. Нийслэлийн Засаг даргын А/805 захирамжийг үндэслэн Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу 2016 оны 11 дүгээр сарын 18-ний өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 31- ний өдрийг хүртэлх хугацаанд агаар бохируудлагч томоохон эх үүсвэрийг магадлан итгэмжлэх, хяналт шалгалт хийсэн. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Олон улсын хамтын ажиллагааны “Жайка” байгууллага, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын Дэд бүтэц тохижилтын хэлтсүүд хамтран агаарт ялгаруулах утааны стандарт хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагын зуухнуудад хяналт шалгалт хийж, шаардлага хүргүүлэн ажилласан.

Энэхүү ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт уурын болон усан халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Агаарын тухай”, “Агаарын бохирдлын төлбөрийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай”, “Газрын тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Эрчим хүчний тухай” хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, журам, стандарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, халаалтын зуухны яндангаас ялгарах хаягдал утаанд хийн хэмжилт хийж магадлан

итгэмжлэх, стандарт хангахгүй зуухнуудыг шинэчлүүлэх санал, дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлэх зорилготой юм.



Магадлан итгэмжлэх ажлын хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүргийн 100 кВт-аас дээш хүчин чадалтай 146 аж ахуйн нэгж, байгууллагын 276 зуухны байгууламжид хяналт шалгалт хийж, 24 зуухны хаягдал утаанд хэмжилт хийн 9 албан шаардлага, 17 дүгнэлт, 4 акт, 6,720,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Мөн 2017 стандартын шаардлага хангаагүй төвийн шугамд ойрхон 70 халаалтын зуухыг холбуулах санал гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлээд байна. Энэхүү ажлын хүрээнд гэр хорооллын 45 халаалтын зуухыг буулгаж, 56 хэрэглэгчийг нь төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг хийсэн. 2017 оны төсвийн тодотголоор гэр хорооллын дулааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, зураг төсөл нь бэлэн болсон 68 халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчийг төвлөрсөн системд холбох 23 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдэж, ажлыг эхлүүлээд байна. Үүний дүнд жилд 17'000 тн түүхий нүүрсний хэрэглээг бууруулах юм.

2. Агаарын чанарыг сайжруулах бүсэд дугуй засвар, гутал засвар, ТҮЦ, павильон, харуулын байр, барилгын ажлын талбай дээрх түр байруудад түүхий нүүрс, резин эдлэл, дугуй зэрэг химийн гаралтай түүхий эд шатаахыг таслан зогсоох ажлын удирдамжийн дагуу НМХГ, Дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран 2547 иргэн, аж ахуй нэгжид шалгалт хийж 1808 мэдэгдэх хуудас, 44 зөвлөмж, 38 албан шаардлага, 15 акт, 6,125,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 124 объектод цахилгаан халаагуур тавиулж, 6 объектын уламжлалт энгийн зуухыг бүрэн шаталтат сайжруулсан зуухаар солиулсан.
3. Зам, Тээврийн хөгжлийн яамнаас баталсан “Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаанд үзлэг хийх ажлын хэсгийн удирдамж”-ийн дагуу утааны тортогжилтын хэмжээг утаа хэмжигч “OP201” зөөврийн багажаар тоноглогдсон явуулын үзлэгийн 5 автомашинтайгаар шугам замд судалгаа хийсэн. Шалгалтад нийт 697 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас 404 тээврийн хэрэгсэл тэнцэж, 293 тээврийн хэрэгсэл буюу 42% нь стандартад заасан хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан. Дизель хөдөлгүүртэй автомашины утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлттэй гарсан автобусанд техникийн засвар үйлчилгээг дахин хийж зөрчлийг арилгуулан, тус газрын техникийн хяналтын үзлэгийн төвд утааны үзүүлэлтийг дахин шалгуулж, үйлчилгээнд гаргахыг анхааруулсан.
4. Япон Улсын ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын “Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл-2”-ийн хүрээнд “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 10 автобусанд “Эко жолоодлого” -ын талаар судалгаа хийх зорилгоор хяналтын камер суурилуулж, мэдээлэл цуглуулах ажлыг 2017 оны 01 дүгээр сард эхлүүлсэн бөгөөд холбогдох мэдээ, мэдээллийг авч байна.

-
5. Баянзүрх дүүргийн шалган бүртгэх товчооны дэргэд автомашинаас ялгарах агаар бохирдуулагч бодисуудыг зайнаас тодорхойлох RSD (Remote Sensing Device) төхөөрөмжийг байршуулж, 2017 оны 04 дүгээр сарын 14-нөөс 21-ний өдрийн хооронд хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслээс ялгарах хаягдал утааг хэт ягаан туяаны шингээлтийн аргаар агууламжийг тодорхойлох (CO, CO₂, HC, NO, PM (S/F) туршилтын ажлыг хийж гүйцэтгэв. Агаар бохирдуулагч хорт бодисуудын ялгаралын босго утгыг Япон болон АНУ-ын нормын хамгийн өндөр утгаар сонгон туршилтын хэмжилтийг хийхэд нийт хэмжилтэнд хамрагдсан тээврийн хэрэгслийн 14 орчим хувь шаардлага хангаж байсан. (Нийт 17091 тээврийн хэрэгсэл хамрагдснаас хүчинтэй хэмжилт хийгдсэн 62.1% буюу 10616 тээврийн хэрэгсэл байв.)
 6. “Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл-2”-ийн хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 13-наас 27-ны өдрийн хооронд өвлийн нөхцөлд тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийн итгэлцүүрийг тогтоох туршилт, судалгааг их багтаамжын “Daewoo bus-106” автобус, Toyota “Prius-20” автомашинд тус тус амжилттай хийлээ.
 7. Гэр хорооллын 28-30 м² талбай бүхий сууцтай нэг өрхийн халаалтын улиралд цахилгаан, хатуу түлш, хийн халаагуур зэргээр дулаан хангамжаа шийдсэн нөхцөлд гарах үр ашгийн тооцоо, судалгааг гаргасан. Энэхүү судалгааны дүнгээс харахад 1 өрх халаалтын улиралд нүүрсэнд 384000 төгрөг зарцуулж байгаа бөгөөд хэрэв тухайн өрх дулаан хангамжаа цахилгаанаар шийдэхэд зардал 2 дахин их, шингэрүүлсэн хий ашиглахад 4 дахин их гарах тооцоо гарсан.

Агаар бохирдуулагч эх үүсвэр тус бүрээс учирч буй нөлөөлийг тогтоох зорилтын хүрээнд:

1. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А-181 дугаар тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор дүүргүүдээс том болон бага оврын усан халаалтын зуух, ахуйн хэрэглээний зуухны тоо бүртгэл, Автотээврийн үндэсний төвөөс Улаанбаатарт хөдөлгөөнд орж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэл мэдээлэл, Улаанбаатар хот дахь гаалийн газраас бензин, шингэрүүлсэн хий, дизель түлшний 2016 оны импортын мэдээ, дулааны цахилгаан станцуудаас нүүрсний хэрэглээний мэдээлэл авч мэдээллийн сангаа шинэчилсэн. Мэдээллүүдийг нэгтгэн ЦУОШГ-т хүргүүлсэн.
2. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн бүртгэл тооллогын мэдээллийг боловсруулан эх үүсвэр тус бүрийн ялгарлыг тооцон “Эх үүсвэрийн ялгарлын инвенторын 2016 оны жилийн тайлан”-г боловсруулж www.aprd.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан. 2016 оны эх үүсвэрүүдийн тооллогын дүн дээр үндэслэн агаарын чанарын тархалтын загварчлалыг тооцоолсон.



3. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн 2015, 2016 оны тархалтын загварчлалаар нийслэлийн зуслангийн 26 амны 17-н байршилд өвлийн улирлын агаарын чанарыг тооцон агууламж болон агаарын чанарын индексээр гаргаж ажиллалаа.

Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны үнийн хөнгөлөлтөнд хамруулах зорилтын хүрээнд:

Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрээр өнгөрсөн оны 11 дүгээр сараас эхлэн гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхүүдийн цахилгааны шөнийн хэрэглээний төлбөрийг 50 хувиар, Засгийн газрын шийдвэрээр 2017 оны 1 дүгээр сараас эхлэн 100 хувь хөнгөлөх ажлыг хэрэгжүүлж ажилласан.

“УБЦТС” ТӨХК нь 349,155 хэрэглэгчтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээтэй. Үүнээс 147,353 хэрэглэгчдийн тарифт тоолуур бүхий 114,512 цэгт 3,363.7 сая төгрөгийн шөнийн хэрэглээний тарифын хөнгөлөлт үзүүлсэн байна.

Шөнийн тариф тэглэсэнтэй холбоотой 1 фазын 543 ширхэг, 3 фазын 154 ширхэг нийт 697 ширхэг тарифт тоолуурыг шинээр нэмж суурилуулсан. Засгийн газрын 199 дүгээр тогтоолоор “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам” батлагдсан.

Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

1. БОАЖЯ, АББҮХ, НЗДТГ, Агаарын бохирдлыг бууруулах газар хамтран "Агаарын бохирдлыг бууруулах технологийн" үзэсгэлэнг 2017 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд Худалдаа аж үйлдвэрийн танхимд зохион байгуулсан. Үзэсгэлэнд 51 аж ахуй нэгж байгууллага оролцсон бөгөөд төрөл бүрийн хийн, цахилгаан, усан халаагуур, зуух, боловсруулсан шахмал түлш, агаар цэвэршүүлэгч, автомашинаас ялгарах бохирдлыг бууруулах шингэн, дулаан алдалт багатай нано барилгын материал үйлдвэрлэгч, импортлогчдоос бүрдсэн. Үзэсгэлэнд Ерөнхий сайд Ж. Эрдэнэбат, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Нийслэлийн ногоон хөгжил, агаарын бохирдолын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан нар оролцож танилцсан.
2. “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын

Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн заалтуудыг хэрэгжүүлэх, Монгол Улсын хэмжээнд Байгалийн хий, хийг боловсруулах, үйлдвэрлэх, түүний ашиглалт, түгээлт, дамжуулалтын сүлжээг цогцоор бий болгох харилцааг төлөвлөгөөтэй нэгдсэн бодлогоор хөгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын Байгалийн хий, хийн салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 36 дугаар ажлын хэсэгт НЗДТГ, НАББГ, ХТЕТГ-аас мэргэжилтнүүд орж ажилласан.

3. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах зорилгоор БОАЖЯ, НЗДТГ, “Үртсэн шахмал түлш” -НӨҮГ –ууд хамтран “Түлш нийлүүлэх гэрээ”-г байгуулсан. Нийслэлийн Засаг даргын агаарын бохирдол, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчоор батлуулсан түлш хүлээж авах ажлын хэсэг 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдөр БГД-ийн агуулахад буулгасан 400 тонн буюу 16000 шуудай түлшийг хүлээж авсан бөгөөд зорилтот бүлгийн иргэдэд нийлүүлэх ажил хийгдэж байна.
4. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/163 дугаар захирамжаар батлагдсан “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 1700 айл өрхөд сайжруулсан түлш олгохоор нээлттэй сонгон шалгаруулалтыг НХААГ-т зарласан. “Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах” НАББГ-2017/ тоот гэрээг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Баялаг Эрдэнэ цом” ХХК-тай байгуулсан. Уг ажлын хүрээнд 1700 тонн сайжруулсан түлш олгохоос одоогийн байдлаар 204 тонн сайжруулсан түлшийг Сонгинохайрхан дүүргийн 1-8,20,22,25 дугаар хороонд буулгаж хүлээлгэн өгсөн.
5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид эрх шилжүүлсний дагуу улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх Агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/588 тоот захирамжаар баталсан. Уг ажлын хүрээнд 2100 тн-оос багагүй сайжруулсан шахмал түлш нийлүүлэх сонгон шалгаруулалтыг 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зарлан 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нээлт хийсэн. Хамгийн сайн үнэлэгдсэн “Монголиан Инвестмент Корпорейшн” ХХК-д 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн боловч Сангийн яаманд гомдол гарсан.
6. Топ 100 аж ахуйн нэгжид нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор тэдгээрийн гэр хороололд амьдардаг ажилтан, албан хаагчид болон бусад иргэдэд цахилгаан халаагуур, стандартын шаардлага хангасан халаалтын тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр худалдан авахад санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлж ажиллах уриалгыг хүргүүллээ.

-
7. Улаанбаатар хотын төвийн дулааны нэгдсэн шугам сүлжээнээс алслагдсан төвийн 6 дүүргийн халаалтын зуухтай 300-600 м² талбай бүхий 55 цэцэрлэг, сургууль, хороодын судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэн тэдгээрийн дулаан хангамжийг эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан эх үүсвэрээр үе шаттай шийдэхээр төлөвлөн ажиллаж байна.

Иргэдэд экологийн боловсрол олгох зорилтын хүрээнд:

1. ЕБС-ын сургуулиудад агаарын бохирдлын байдлын талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, танилцуулах зорилгоор “Жайка” төслийн багийн зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран 2017 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд БГД-ийн 3, СБД-ийн 4, ЧД-ийн 4, ХУД-ийн 5, БЗД-ийн 6, СХД-ийн 8, нийт 30 сургуульд ЛЕД дэлгэц суурилууллаа.
2. 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т иргэдэд суурин эх үүсвэрийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмж, байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, 140 гаруй иргэдээс санал асуулга авч ажилласан.
3. “ЖАЙКА” олон улсын байгууллагын “Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх 2 дугаар үе шатны” төслийн хаалтын тайлангийн хэлэлцүүлгийг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-д зохион байгууллаа.
4. 2017 оны 09 дүгээр сарын 28-30-ний өдрүүдэд "Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи" үзэсгэлэнг зохион байгуулсан. Үзэсгэлэнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 50 аж ахуйн нэгж, байгууллагууд оролцсон.
5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний чуулган”-ыг хамтран зохион байгуулж ажилласан.
6. Нийслэлийг цэвэр агаартай, эрүүл, аюулгүй амьдрах орчин болгох, агаарын бохирдлоос эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулахад иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, шинэлэг санал, шийдлийг хэлэлцэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХАД ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦОО” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах зорилтын хүрээнд:

1. Улаанбаатар цэвэр агаар” төсөл, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран “Улаанбаатар хотын гэр хороолол дахь хүүхдийн 4 цэцэрлэгийн 25 ангид дотоод орчны агаарын чанарыг сайжруулах интервенц хэмжилт судалгааны ажил хийсэн.

-
2. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/804 дугаарт захирамжийн хүрээнд агаарын бохирдол ихтэй бүсийн гэр хорооллын 206 эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах судалгааг гарган, улмаар 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ба гэр хорооллын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжсэн тэмдэглэл гарсан.
 3. Нийслэлийн 2017 оны төсвөөр 21 ерөнхий боловсролын сургуулийн бага ангид 150, 11 эрүүл мэндийн төвийн хүүхдийн эрчимт эмчилгээний болон хэвтүүлэн эмчлүүлэх тасагт 200, мөн Улаанбаатар Цэвэр агаар төслийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр 79 цэцэрлэгт 750, нийт 1100 агаар цэвэршүүлэх төхөөрөмжийг нийлүүлсэн. Ингэснээр бага ангийн 11 мянга, 2-5 насны 12 мянган хүүхдийн сурах таатай нөхцөл, 50 мянга гаруй хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн эмчилгээний орчин, нөхцөл бүрдүүлсэн.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

Байгууллагын мэдээллийн технологи, компьютер техник хангамжийн найдвартай ажиллагааны талаар:

Байгууллагын мэдээллийн технологи, компьютер техник хангамжийн талаарх судалгааг Нийслэлийн мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Байгууллагын компьютерт хортой кодноос хамгаалах программ худалдаж авахаар Нийслэлийн мэдээллийн технологийн газар, Софтлайн Азия ХХК-тай гурвалсан гэрээ байгуулсан.

Нийслэлийн агаарын чанарын суурин харуулын мэдээг цагт тухайд нь онлайнаар www.agaar.mn, www.air.ub.gov.mn, www.aqicn.org сайтуудаар иргэдэд мэдээллэж байгаа бөгөөд суурин харуулын байршил бүрд ЛСД дэлгэцээр мөн БОАЖЯам, Хангарди ордон, ЦУОШГ-ын үүдэнд нийт 4 ТВ дэлгэцээр, мөн гар утасны “Агаар” аппликейшнээр дамжуулан олон нийтэд шууд хүрч байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт байрлах агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо байгууллага бүрт өөр байдаг. Энэ нь агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн ангилал, хүчин чадал, ялгаруулж буй бохирдлын хэмжээг бүртгэл хийдэг анхан шатны хүмүүс мэддэггүй, мэдээллийг бүрэн цуглуулж амждаггүй, нэгдсэн мэдээллийн сан байдаггүй зэрэгтэй холбоотой. Асуудлыг шийдвэрлэж үнэн зөв мэдээллээр нэгдсэн мэдээллийн сантай болсноор агаарын бохирдлыг бууруудах арга хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох боломжтой болно. 2017 онд “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл тооллого явуулах, бүртгэл мэдээллийн цахим сан бүрдүүлэх” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлан гүйцэтгүүлсэн. Тус бүртгэл тооллогын системийг хийлгэсэнээр бүртгэл тооллого явуулах хугацаа 4 сар байснаас 1 сар болж богиноссон. Агаарын бохирдлын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага, судлаач эрдэмтэд цахим хуудсаар мэдээлэл авах, бүгд нэг эх үүсвэрээс ижил мэдээлэлтэй болох боломжтой болсон. Энэ системийг нэвтрүүлснээр өмнөх цахим хуудас интерфэйс муутай, санал асуулга авах, видео тоглуулах функцгүй байсан нь шинэчлэгдэж бид өөрсийн мэдээ

мэдээллээ цаг тухайд нь мэдээллэх боломжтой болсон. Энэхүү ажлын зөвлөх үйлчилгээг “БИД СОЛЮШН” ХХК–иар гүйцэтгүүлж 2017 оны 11 дүгээр сарын 30-нд эцсийн тайланг хүлээн авсан. Мөн тус программ хангамжийг ашиглах талаар байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. Одоо онлайн орчинд байршуулах, байгууллагын өмчид бүртгэх ажил явагдаж байна.

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31 ний өдрийн А/635 дугаар захирамжаар Дарга, Орлогч дарга, Захиргааны хэлтэс, Бодлого, зохицуулалтын хэлтэс, Агаарын чанарын хэлтэс бүхий 20 хүний бүрэлдэхүүнтэй батлагдан ажиллаж байна. Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний 2016 оны тайлан мэдээг гаргаж цахимаар болон цаасаар Нийслэлийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэв. Газрын хэмжээнд оны эхэнд 18 албан хаагч үр дүнгийн гэрээ, 1 албан хаагч хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаагаас хагас жилийн байдлаар үр дүнгийн гэрээ 17 албан хаагч дүгнүүлж 2 албан хаагч албан хаагч задгай тайлан бичиж нийт 19 албан хаагч ажлаа тайлагнасан бол жилийн эцсийн байдлаар 13 албан хаагч үр дүнгийн гэрээ дүгнүүлж 6 албан хаагч задгай тайлан бичин нийт 19 албан хаагч ажлаа тайлагнав.

Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд 5 албан хаагчдад зэрэг дэвийг нэмэгдүүлж олгохоор санал хүргүүлж, НЗД-ын А/171 дүгээр захирамжаар батлагдав. Нэмэгдлийг 2017 оны 04 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн. Мөн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид олгож эхэлсэн.

Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдээс ялгарах хүлэмжийн хийн ялгарлын бүртгэл тооллого /emission inventory/-ийн сургалтанд 6 мэргэжилтэн хамрагдан сертификат авсан. Архивын ерөнхий газрын “Архив, Албан хэрэг хөтлөлт”-ийн 1 сарын сургалтанд 1 мэргэжилтэн хамрагдан “А” үнэлгээтэй төгссөн. Худалдан авах ажиллагааны сургалтанд 2 мэргэжилтэн хамрагдаж А/3 гэрчилгээ авсан. НЗДТГ-ын ХШҮХ-ийн зохион байгуулсан “L Monitoring”-ийн сургалтанд 5 хүн хамрагдаж, 1 мэргэжилтэн сертификат авсан.

Агаарын бохирдлыг бууруулахад олон улсын туршлагыг судлах зорилгоор Япон болон АНУ-д 2 албан хаагч семинарт оролцон тухайн орны туршлагыг судалж, мэдлэг, ур чадвараа ахиулсан.

2017 оны жилийн эцсийн ажлын үзүүлэлтээр ур чадвар, үр дүнг үнэлэн, Төрийн одон медальд 1, Байгаль орчны “Тэргүүний ажилтан”-д 2, Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-т 2 албан хаагчийг тус тус тодорхойлсноос Байгаль орчны “Тэргүүний ажилтан” тэмдэгээр 1 албан хаагч, Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 1 албан хаагч шагнагдаж, 14 албан хаагчид мөнгөн урамшуулал олгосон.

Нийт албан хаагчдад сар бүр олгох хоолны мөнгө 52000 төгрөг, унааны мөнгө 10000 олгож, ажлын байрны таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан үзлэг шинжилгээнд 100 хувь хамрагдсан.

“Сүү” ХК-тай “Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ” байгуулан “Сүүгээр эрүүлжье” хөтөлбөрт нийт 12 албан хаагчийг хамруулан 1 сарын турш 300,000 төгрөгийн үнэ бүхий сүү, тараг, аарцаар ажлын байранд үйлчилгээ үзүүлсэн.

Төсөв санхүү, орлого бүрдүүлэлтийн чиглэлээр

2017 оны 12 дугаар сарын 11-ний байдлаар 775,826,100.00 төгрөгийн урсгал санхүүжилт авч, 15,522,812.00 төгрөгийн орлого олсон. Үүнээс:

- Агаар орчин болон агаар бохирдуулагч эх үүсвэрт хийсэн хэмжилтийн орлого: 15,522,812.00төг

Нийт 383,102,621.00 төгрөгийг зарцуулсан. Үүнээс:

- Цалин хөлс 183,904,507.00 төг
- Бараа үйлчилгээний зардал 196,368,464.00төг
- Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал 2,829,650.00төг

Архивын албан хэргийн хөтлөлтийн талаар

Газрын 2009-2016 оны архивын баримт бичгийн хөтлөлтийг WORD файлаас EXCEL программд шилжүүлэн шивж дуусгасан. Архивын бичиг баримтыг газрын албан хаагчдаас хүлээн авч бүртгэн, архивийн баримтыг EXCEL-ийн шинэ дугаараар тоолон нэгж тус бүрээр бүртгэж он, оноор шинэчлэн бүртгэж, байнга, түр, 70 жилээр ангилан эмхэлж цэгцэлсэн.

2016 оны А тушаал, Б тушаалуудыг Archive eDoc программд шивж оруулсан.

2015 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2016 оны архивын баримтыг хуваарийн дагуу нэгж хэлтсүүдээс хүлээн авсан. Үүнд:

- Бодлого хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсээс нийт - 11
- Захиргаа удирдлагын хэлтсээс нийт - 50
- Хяналт үнэлгээний хэлтсээс нийт - 4 баримт тус тус хүлээн авсан.

Албан бичгийн шийдвэрлэлтийн талаар

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд edoc.ub.gov.mn цахим программыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэв. Тайлант хугацаанд нийт 687 албан бичиг хүлээн авсны 466 нь хариугүй, хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн 221, судлагдаж буй 42, хугацаа хэтэрсэн 49 албан бичиг байна. Шийдвэрлэлтийн дундаж үзүүлэлт 92,30 %-тай байна. Нийт гадагш төлөвлөн хүргүүлсэн 554 албан бичиг байна.

№	Нэгж/ хэлтэс	Нийт	Хариугүй	Хариутай	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч	Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэлт
1	Агаарын чанарын хяналтын хэлтэс	178	111	67	157	18	2	94.70%
2	Бодлого зохицуулалтын хэлтэс	213	160	53	180	10	23	88.48%
3	Захиргааны хэлтэс	273	175	98	241	20	14	93.25%
4	Удирдлага	22	19	3	18	1	3	85,09%
	Нийт	687	466	221	596	49	42	92.30%

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг цаг тухайд нь бүрэн шийдвэрлүүлэх тал дээр албан хаагчидтай хамтран ажиллаж байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай уулзах иргэний уулзалт 20, өргөдөл, гомдол, хүсэлт 94 ирүүлснийг бүрэн шийдвэрлэсэн. 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 15 хоног 06 цаг 40 минут болсон нь өмнөх оны жилийн эцсийн байдалтай харьцуулбал 1 хоног орчмоор буурсан байна.

Нэгж/хэлтэс	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Шийдвэрлэж хариу өгсөн
Удирдлага	4	0	4
Захиргаа удирдлагын хэлтэс	7	0	7
Бодлого зохицуулалтын хэлтэс	63	4	63
Агаарын чанарын хяналтын хэлтэс	20	0	20

Нийт	94	4	94
------	----	---	----

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 100% гүйцэтгэж ажилласан.

Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд тайлан мэдээ хүргүүлсэн талаар

МУ-ын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журам” НЗ даргын 2017 оны А/335 дугаарт захирамжаар “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын талаар хэлтсүүдэд сургалтыг зохион байгуулсан. Жилийн тайлан мэдээг уг журмын 1-р хавсралтаар баталсан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн холбогдох газарт хүргүүлснээс гадна monitoring.ub.gov.mn цахим хуудсаар тухай бүр тайлагнан ажиллаж байна. Одоогийн байдлаар Эрх зүйн тайлан, Гадаад харилцааны ажлын тайлан, Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын тайлан, Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, УИХ, ЗГ-ын тогтоол, шийдвэр, албан даалгаварын биелэлт, НИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр, НЗД-ын захирамж зэрэг баримт бичгүүдийн жилийн тайлан мэдээг хүргүүлээд байна.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав салбарт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хүний нөөцийн нээлттэй өдөрлөгт оролцож 100 гаруй иргэнд тус газрын танилцуулга, үзүүлэх үйлчилгээний талаар мэдээлэл хийж, ажлаа сурталчилсан.

НҮБ-аас хүн төрөлхтөний өмнө тулгамдаад байгаа байгаль орчны асуудалд анхаарал хандуулах, байгаль дэлхийгээ хайрлаж хамгаалахад улс орон бүр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэн 1972 оноос эхлэн жил бүрийн 06 дугаар сарын 05-ны өдрийг “Дэлхийн байгаль хамгаалах өдөр” болгон тэмдэглэдэг болсон. Тус өдрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа байгууллагууд, Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар үйл ажиллагаагаа сурталчлах өдөрлөгийг Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газраас агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөх техник, технологиуд, нийслэл хотоос хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа мэдээллүүдийг түгээж ажилласан.

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд танилцуулах, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах зорилго бүхий “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологи” үзэсгэлэнг 2017 оны 09 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Үзэсгэлэнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Нийтийн тээврийн

газар, Нийслэлийн Гэр хороолол дэд бүтцийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Үйлдвэрлэл инновацийн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Газрын алба, Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрууд оролцож үйл ажиллагаагаа иргэддээ танилцуулсан. Мөн Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 50 аж ахуйн нэгж, байгууллагууд оролцсон. Үзэсгэлэнтэй холбоотой мэдээ мэдээллийг байгууллагын вэб хуудсанд байршуулсан.

2017 оны байгууллагын төсвийн төлөвлөгөө, мэдээ, тайлан, гүйлгээ, хөрөнгө гаргахтай холбоотойгоор гарсан тушаал, шийдвэр, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлүүдийг шилэн дансны мэдээлэл тавих хугацааны дагуу байршуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны А/163 захирамжаар батлагдсан “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд төсөл арга хэмжээний урилга зарлалыг хууль журамд нийцүүлэн өдөр тутмын сонин хэвлэл болон www.tender.gov.mn, www.aprd.ub.gov.mn хуудсуудаар дамжуулан олон нийтэд ил тод мэдээллэсэн.

Байгууллагын үйл ажиллагаа эрхэм зорилго зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажлын явц мэдээлэл болон тэдгээртэй холбоотой захирамж, тогтоол, шийдвэрийг байгууллагын цахим хуудас болох www.aprd.ub.gov.mn хуудсанд тухай бүр шинэчлэн оруулж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаас гаргасан 03/03 зөвлөмжид “Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх” асуудал тусгагдсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар “Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөө”-г баталсан. Тусгай төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын мэдээллийг байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээллийн албаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээллэсэн. Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 10/14 тогтоолын хавсралтаар батлагдсан Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, орчны бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээний тусгай төлөвлөгөө /5-9сар/ батлагдсантай холбоотой тогтоол захирамжийг байршуулсан.

2017 оны байдлаар дараах мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. Үүнд:

❖ Хууль эрхзүй, Захирамж, тогтоол	10
❖ Цаг үеийн мэдээ	34
❖ Хэмжилт судалгаа	7
❖ Ил тод байдал, тайлан мэдээ	16

Нийт вэб хуудсаар орж мэдээлэл авсан хандалтын тоо 48838 байна.

НЗДТГ-н Хэвлэл мэдээллийн албанд газрын үйл ажиллагаатай холбоотой улиралд хийсэн онцлох мэдээ мэдээллийг албан бичгээр болон цахим хуудсаар хүргүүлж байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний талаар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа байгууллагууд, Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар үйл ажиллагаагаа сурталчлах өдөрлөгийг Д.Сүхбаатарын талбайд 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр буюу “Дэлхийн Байгаль хамгаалах өдөр”-ийн “Нээлттэй Хаалганы өдөрлөг”-г оролцсон хөндлөнгийн болон иргэдээс “Санал хүсэлт”-ийн хуудас бөглүүлэн санал асуулга явуулсан.

- Гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэх
- Иргэдийн экологийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх
- Шахмал түлш боловсруулж, айл өрхүүдээр хэрэглүүлж заншуулах түүнд хяналт тавих
- Нийтийн тээврийн хэрэгслийг сайжруулах
- Агаарын бохирдлыг бууруулах оновчтой шийдэл олж түргэн шуурхай арилгах
- Цахилгаан халаагуур нэвтрүүлэх
- Орон сууцжуулах
- Ногоон хүрээлэн буй орчин бүрдүүлэх
- Тээврийн хэрэгслийг цөөлөх, тээврийн хэрэгслээс ялгарч буй утааг бууруулах түүнд хяналт тавих
- ДЦС барьж ашиглалтад оруулах
- Цахилгааны төлбөрийг бууруулах /бүтэн жилийн турш/
- Агаарын бохирдлын тухай мэдээ мэдээлэл, ойлголт олгох
- Оновчтой төсөл хэрэгжүүлэх, хяналт явцыг сайжруулах

Өдөрлөгт оролцсон 142 иргэн судалгаа бөглөж, санал хүсэлт, үзэл бодлоо илэрхийлсэн. Агаарын бохирдлын гол эх үүсвэр: гэрийн зуух, авто тээврийн хэрэгслээс ялгарч буй утаа, зориултын бус түлш буюу дугуй, хог, шороо, тоос тоосонцор гэсэн хариулт өгсөн.

Дийлэнх оролцогчдын судалгааг дүгнэвэл:

- ❖ Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын үйл ажиллагаа, агаарын чанарын мэдээллийг телевиз, сошиал мэдээллийн хэрэгслээр хүлээн авдаг байна.
- ❖ Агаарын чанарын мэдээллийг улирлын чанартай хүлээн авч улиралд 1 удаа гэсэн.
- ❖ Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын эрхлэн ажилуулдаг “Агаар” аппликейшнийг олонхи оролцогчид ашигладаггүй гэсэн хариулт өгчээ.

Шинэ санаачлага, бүтээлч ажлын талаар

Авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах зорилгоор МУ-д анх удаа “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 10 автобусанд “Эко жолоодлого” -ын талаар судалгаа хийх зорилгоор хяналтын камер суурилуулж,

мэдээлэл цуглуулах ажлыг 2017 оны 01 дүгээр сард эхлүүлсэн бөгөөд холбогдох мэдээ, мэдээллийг авч ажиллаж байна.

Баянзүрх дүүргийн шалган бүртгэх товчооны дэргэд автомашинаас ялгарах агаар бохирдуулагч бодисуудыг зайнаас тодорхойлох RSD (Remote Sensing Device) төхөөрөмжийг байршуулж, 2017 оны 04 дүгээр сарын 14-21 -ий хооронд хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслээс ялгарах хаягдал утааг хэт ягаан туяаны шингээлтийн аргаар агууламжийг тодорхойлох (CO, CO₂, HC, NO, PM (S/F) туршилтын ажлыг анх удаа хийж гүйцэтгэв. Агаар бохирдуулагч хорт бодисуудын ялгарлын босго утгыг Япон болон АНУ-ын нормын хамгийн өндөр утгаар сонгон туршилтын хэмжилтийг хийхэд нийт хэмжилтэнд хамрагдсан тээврийн хэрэгслийн 14 орчим хувь шаардлага хангаж байсан. (Нийт 17091 тээврийн хэрэгсэл хамрагдснаас хүчинтэй хэмжилт хийгдсэн 62.1% буюу 10616 тээврийн хэрэгсэл байв.)

Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ тогтоох тухай БОАЖЯ-ны 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/342 тушаалыг баримтлан агаарын чанарт нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд агаарын чанарын хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон тул энэхүү тушаалыг өөрчлөх төслийн саналыг боловсруулж, НЗД-ын Удирдлагын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Энэхүү төслийн санал уг хурлаар дэмжигдсэн тул тушаалын төслийг БОАЖЯ-руу хүргүүлээд байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт байрлах агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо байгууллага бүрт өөр байдаг. Энэ нь агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн ангилал, хүчин чадал, ялгаруулж буй бохирдлын хэмжээг бүртгэл хийдэг анхан шатны хүмүүс мэддэггүй, мэдээллийг бүрэн цуглуулж амждаггүй, нэгдсэн мэдээллийн сан байдаггүй зэрэгтэй холбоотой. Асуудлыг шийдвэрлэж үнэн зөв мэдээллээр нэгдсэн мэдээллийн сантай болсноор агаарын бохирдлыг бууруудах арга хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох боломжтой болно. 2017 онд “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл тооллого явуулах, бүртгэл мэдээллийн цахим сан бүрдүүлэх” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлан гүйцэтгүүлсэн. Тус бүртгэл тооллогын системийг хийлгэсэнээр бүртгэл тооллого явуулах хугацаа 4 сар байснаас 1 сар болж богиноссон. Агаарын бохирдлын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага, судлаач эрдэмтэд цахим хуудсаар мэдээлэл авах, бүгд нэг эх үүсвэрээс ижил мэдээлэлтэй болох боломжтой болсон. Энэ системийг нэвтрүүлснээр өмнөх цахим хуудас интерфэйс муутай, санал асуулга авах, видео тоглуулах функцгүй байсан нь шинэчлэгдэж бид өөрсдийн мэдээ мэдээллээ цаг тухайд нь мэдээллэх боломжтой болсон.

Улаанбаатар хотын агаарын чанарт нөлөөлж болзошгүй байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих агаарын чанарын хяналтын үйл ажиллагааг 2017 оноос эхлэн манай байгууллагын хяналтын хэлтсийн мэргэжилтнүүд бие даан зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү хэмжилт нь Жайка төслийн хүрээнд хэрэгжүүлсэн суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилтийн арга хэмжээтэй дүйхүүц томоохон эх үүсвэрийн бие даасан хэмжилтийн төрөл бөгөөд энэхүү хэмжилтээр дамжуулан халаалтын болон халаалтын бусад улиралд Улаанбаатар хотын агаарын чанарт

нөлөөлж байгаа байгууллагын үйл ажилаагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжыг бүрдүүлнэ.

Хэмжилтэд хамаарагдах эх үүсвэрүүдийг дурьдвал:

1. Бүтээн байгуулалтын ажлын үеэр агаарт дэгдэх сөрөг нөлөөллийг тогтоох
2. Барилгын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа олборлох болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох
3. Улаанбаатар хотын суурьшлын бүс дотор агаарын чанарт нөлөөлж байгаа томоохон эх үүсвэрийг тодорхойлох /ДЦС-ын үнсэн сан, Барилгын материалын захууд, 100 айлын барилгын материалын зах гм/

ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн удирдах ажилтны 23 удаагийн шуурхайгаас өгөгдсөн 58 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнав.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаас гаргасан 03/03 зөвлөмжид “Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх” асуудал тусгагдсан. Энэхүү зөвлөмжийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, харъяа байгууллагуудтай хамтран “Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөө”-г боловсруулан, НИТХ-аар хэлэлцүүлэн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 07/01, 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 10/14 дугаарт тогтоолуудаар батлуулан, хэрэгжилтийн биелэлтийг 7 хоног бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажилласан.

Нийслэлийн Засаг даргын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан захирамжуудыг сурталчлан таниулах зорилгоор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нартай хамтран 2017 оны 02 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд дээр сургалт зохион байгуулсан. Мөн Замын хөдөлгөөний удирдлагын төв, Орон Сууц Нийтийн Аж Ахуйн Удирдах ТӨҮГ-ын хүсэлтээр тухайн байгууллагын гэр хороололд амьдардаг 400 гаруй ажилтан, албан хаагчдад агаарын бохирдол, өнөөгийн байдал, цахилгааны хөнгөлөлт, нийслэлээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар 2017 оны 03 дугаар сарын 14-нд сургалт зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын санаачилсан “Иргэдээ сонсьё” аяны хүрээнд төвийн 6 дүүргийн хороодуудад агаарын бохирдлын өнөөгийн байдал, түүнийг бууруулах чиглэлээр төрөөс баримтлаж буй бодлогын талаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын их танхимд 2017 оны 05 дугаар сарын 22-ний өдөр Монгол Улсын Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн Агаарын бохирдлын бууруулах газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хамтран “Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагуудыг магадлан итгэмжилсэн ажлын тайлан, цаашид авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтанд нийслэлийн төвийн 6-н

дүүргийн 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух эзэмшигч байгууллагуудын төлөөлөл оролцсон.

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Улаанбаатар Цэвэр агаар төслийн нэгжтэй хамтран “Дулаалга аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдэд зориулсан сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 29-нд Дүнжингарав Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд зохион байгууллаа.

НҮБ-аас хүн төрөлхтөний өмнө тулгамдаад байгаа байгаль орчны асуудалд анхаарал хандуулах, байгаль дэлхийгээ хайрлаж хамгаалахад улс орон бүр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэн 1972 оноос эхлэн жил бүрийн 06 дугаар сарын 05-ны өдрийг “Дэлхийн байгаль хамгаалах өдөр” болгон тэмдэглэдэг болсон. Тус өдөрлөгт Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа байгууллагууд, нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар, нийслэлийн Байгаль орчны газар, нийслэлийн Аялал жуулчлалын газар оролцсон. Өдөрлөгийн үеэр байгууллагын зүгээс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хотоос хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны мэдээлэл өгөхийн зэрэгцээгээр байгаль орчинд ээлтэй техник, технологиудыг сурталчилж ажиллалаа.

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд танилцуулах, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах зорилго бүхий “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологи” үзэсгэлэнг 2017 оны 09 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Үзэсгэлэнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Гэр хороолол дэд бүтцийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Үйлдвэрлэл инновацийн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Газрын алба, Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газрууд оролцож үйл ажиллагаагаа иргэддээ танилцуулсан. Мөн Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 50 аж ахуйн нэгж, байгууллагууд оролцсон.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний чуулган”-ны хамтран зохион байгуулан ажилласан.



Нийслэлийг цэвэр агаартай, эрүүл, аюулгүй амьдрах орчин болгох, агаарын бохирдлоос эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулахад иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, шинэлэг санал, шийдлийг хэлэлцэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХАД ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦОО” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээллийн талаар

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 зорилт бүхий 44 хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан байна. Энэхүү хэрэгжүүлэх арга хэмжээнээс удаашралтай, эрчимжүүлж ажиллах шаардлагатай

Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан "Агаарын бохирдлыг бууруулах" мастер төлөвлөгөөг шинэчлэн батлуулж хэрэгжүүлэх арга хэмжээнд анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэж байгаа агаарын чанарт нөлөөлж болзошгүй 39 аж ахуйн нэгжийн орчинд агаарын чанарын хөдөлгөөнт AQMS-9000 хөдөлгөөнт харуул болон суурин эх үүсвэрийн цогц багажаар хэмжилт хийж, хэмжилтийн дүнгийн нэгтгэлийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хүргүүлээд байна. Үүнд: "Айзава Монгол" ХХК, "Шар Монгол" ХХК "Энвайрон" ХХК, "Тайм скүэйр" ХХК, "ЭиПи Ти" ХХК, "Эко Констракшн" ХХК, "Түмэн шувуут" ХХК, "Мөнххада" ХХК, "Алтан оршихуй" ХХК, Оргил зуурмаг ХХК, "Жи Эс Дорны хөгжил" ХХК, "Эйч Ди Ти Эм" ХХК, "Нарангийн гол" ХХК, "Аман Токо" ХХК, "Гуру травел" ХХК, "Монгол тамхи Со" ХХК, "Петровис" ХК-ны Шатахуун агуулах станц гэсэн байгууллагууд хамрагдаж, нийслэлийн төсөвт 15,5 сая төгрөгийг төвлөрүүлж ажиллалаа.

"Альфа энержи" ХХКомпаний хүсэлтийн дагуу тус байгууллагаас санал болгосон агаар бохирдуулагч томоохон эх үүсвэр өөрөөр хэлбэл халаалтын зуухнаас агаарт хаягдах тоосонцрыг бууруулах шүүлтүүрт үр ашигтай эсэхийг тодорхойлох хэмжилт хийж, дүгнэлт гаргасан.

2017 оны 3 дугаар сарын 30-нд Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран Улаанбаатар хотын төвд байрлалтай 44 захын орчимд агаар хөрсний шинжилгээ хийсэн бөгөөд энэхүү хэмжилтээр тус захын барилгын материал буулгах цэг, цемент ачиж буулгах цэг, орох гарах үүдний орчимд 180 минутын тасралтгүй хэмжилт хийлээ. Хэмжилтээр "Барилгын материалын 44" захын цемент буулгах талбайгаас агаарт дэгдэх PM10 тоосонцрын хэмжээ хамгийн их утга 1800мкг/м3 хүрч байсан бөгөөд нэг цагийн дундаж нь 949 мкг/м3 буюу стандартаас 4,7 дахин их байсан нь Улаанбаатар хотын агаар дахь тоосонцрын томоохон эх үүсвэрээр тодорхойлогдож байна. Энэхүү хэмжилтийн дүнг НЗД-ын орлогч Ж.Батбаясгалан даргад танилцуулж, ЗТХЯ-нд хүргүүлээд байна.

2017 оын 03 дугаар сард "Lubricon Mongolia" ХХК-ийн шатахууны хэмнэлт үзүүлэх, шаталтаас үүсэх бохирдлыг бууруулах зориулалттай шингэн бүтээгдэхүүний туршилтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Хэмжилтэд бага оврын дизель хөдөлгүүртэй автобус /микро/, бензин хөдөлгүүртэй аксент зэрэгийг тээврийн хэрэгслийг хамруулсан.

2017 оны 3 дугаар сарын 30-нд Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран Улаанбаатар хотын төвд байрлалтай 44 захын орчимд агаар хөрсний шинжилгээ хийсэн бөгөөд энэхүү хэмжилтээр тус захын барилгын материал буулгах цэг, цемент ачиж буулгах цэг, орох гарах үүдний орчимд 180 минутын тасралтгүй хэмжилт хийлээ. Хэмжилтээр "Барилгын материалын 44" захын цемент буулгах талбайгаас агаарт дэгдэх PM10 тоосонцрын хэмжээ хамгийн их утга 1800мкг/м3 хүрч байсан бөгөөд нэг цагийн дундаж нь 949 мкг/м3 буюу стандартаас 4,7 дахин их байсан нь Улаанбаатар

хотын агаар дахь тоосонцрын томоохон эх үүсвэрээр тодорхойлогдож байна. Энэхүү хэмжилтийн дүнг НЗД-ын орлогч Ж.Батбаясгалан даргад танилцуулж, ЗТХЯ-нд хүргүүлээд байна.

“Био фильтр” ХХК-ий дизель хөдөлгүүрийн тортогжилт бууруулах ноосон шүүлтүүрийн туршилтын ажлыг “Daewoo bus-106” автобусанд 2017 оны 05 дугаар сард хийлээ. Туршилтын ажлын явцад ноосон шүүлтүүр шатсанаар хэмжилтийн ажлыг зогсоож, тус шүүлтүүрийг санал болгосон “Био фильтр” ХХК-ий төлөөлөлд өндөр температурт тэсвэртэй органик бус зүйлээр орлуулан хийх зөвлөмж өглөө.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

1. Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамааралгүй дараах тогтоол, шийдвэрийг хяналтаас хасуулах саналтай байна. Үүнд:

- Засгийн Газрын 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаарт “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 3-р заалт “Шинэ суурьшлын бүсэд баригдах инженерийн шугам сүлжээнд холбогдох орон сууцны үнийг бодит өртөг, зардалтай нь уялдуулан тогтоох чиглэлээр барилгын салбарын ААН, байгууллагатай хамтран ажиллах”

- Засгийн Газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 214 дугаарт “Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгаан тарифын хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 4-р заалт “Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах 11,072.0 (арван нэгэн тэрбум далан хоёр сая) сая төгрөг, цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлтийн үйлдвэрлэл, импортыг хангах нэмэгдэл зардалд шаардагдах 21,036.3 (хорин нэгэн тэрбум гучин зургаан сая гурван зуун мянган) сая төгрөгийг төсвийн тодотголд тусгаж, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэх”

2. Монгол улсын Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 05 сарын 19-ний өдрийн А-181 дугаар тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-аар том болон бага оврын усан халаалтын зуух, ахуйн хэрэглээний зуухны бүртгэл тооллогыг тухайн оны 9 дүгээр сарын 15-аас 12 дугаар сарын 10-ны хооронд хийдэг. Нийслэлийн зүгээс том болон бага оврын усан халаалтын зуух хяналт, шалгалт хийх ажлыг 11 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд явуулдаг. Мөн нөгөөтэйгүүр эдгээр зуухны ангилал, хүчин чадлын стандарт өөрчлөгдсөн. Иймд төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг оновчтой болгох үүднээс тус нэгдсэн бүртгэл тооллого явуулах журмыг шинэлэх.

3. Одоогийн хэрэгжүүлж байгаа хэмжилтийн чиглэлүүдэд тулгуурлан эх үүсвэрүүд рүү чиглэсэн агаарын чанарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний саналыг боловсруулж, удирдах дээд шатны байгууллагуудад хүргүүлж, холбогдох

байгууллага иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог хангах ажлыг эрчимжүүлэх.

4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 15 хоног байгааг багасгаж нийслэлээс тавьж байгаа нэг оронтой тоонд хүргэх гэсэн зорилтод хүрэх

5. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлж ажиллах.

Тайлан бичсэн:

Захиргааны хэлтсийн дарга

О.Мягмарсүрэн

ХЯНАСАН:

ДАРГА

М. ДЭЛГЭРЭХ